



**ХЭНТИЙ АЙМГИЙН БЭРХ ХОТЫН
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 11 сарын 17 өдөр

Дугаар А/19

Бэрх хот

**Хөрөнгө
зарцуулах тухай**

Монгол Улсын "Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай" хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дах заалт, Захирагчийн ажлын албаны даргын 2021 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн "Ахмадын сангийн журам батлах тухай" А/36 дугаар тушаалын 4.2.6 дах заалт, Ахмадын сангийн зөвлөлийн 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн №04 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Захирагчийн ажлын албаны ахмад настан О.Энхтуяа, Д.Ариунаа, А.Наквас нар нь Хэнтий аймгийн ахмадын сувилалд эмчлүүлсэн тул 168.000 төгрөгийн төлбөрийг зарцуулсугай.

2.Тус 168.000 (нэг зуун жаран найман мянган) төгрөгийг нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалын зардлаас зарцуулахыг нягтлан бодогч (Г.Осгонжаргал)-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн албаны дарга (П.Янжмаа)-д даалгасугай.

ДАРГА


Э.МЯГМАРСҮРЭН

232502029

Ахмадын сангийн зөвлөлийн хурал

№ 04

Хурал: 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 11⁰⁰ цагт Ахмадын сангийн зөвлөлийн дарга П.Янжмаа, гишүүд Ж.Гэрэлтуяа, Д.Ариунаа нарын бүрэлдэхүүнтэй эхэллээ.

Хэлэлцэх асуудал:

Ахмад настангуудаа сувилалд амраах

Сонссон нь:

П.Янжмаа: Энэ өдрийн мэндийг хүргэе. Өнөөдрийн энэ хурлаар манай Захирагчийн ажлын албанаас тэтгэвэртээ гарсан ахмад настангуудаа ахмадын сувилалд амраах талаар хэлэлцэх гэж байна. Манайд нийтдээ зургаан ахмад настан байгаа. Аймгийн ахмадын сувилалд амрах эрх байгаа тул ахмадуудаасаа санал авч явах хүн байвал дэмжлэг үзүүлье.

Д.Ариунаа: Т.Шижир-Эрдэнэ, Ц.Саранцэцэг хоёр өмнөх ээлжинд амарсан.

П.Янжмаа: Одоо энэ ээлжинд О.Энхтуяа, Д.Ариунаа, А.Наквас 3 ахмадаа амраах саналтай байна.

Ж.Гэрэлтуяа: Манай зөвлөлөөс ахмадын сангийн журмын 4.1.6 д. заагдсан 2 жилд 1 удаа амралт, сувилалд амрахад дэмжлэг олгоно гэсэн заалтын дагуу ахмадууддаа мөнгөн урамшуулал олгоё.

П.Янжмаа: Сувилпын төлбөр нь 1 хүний 56,000 төгрөг юм байна. Иймд 3 ахмаддаа тус бүр 56,000 төгрөг буюу нийт 168,000 төгрөгийн дэмжлэгийг олгох саналтай байна.


Д.Ариунаа: Зөвшөөрч байна.

Ж.Гэрэлтуяа: Санал нэгтэй байна гэснээр хурал 11:25 цагт өндөрлөлөө.

Шийдвэрлэсэн нь:

ЗАА-ны харъяат 3 ахмад настан сувилалд эмчлүүлэх 168,000 төгрөгийн төлбөрийг олгох.

ТАНИЛЦСАН:

ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД:  П.ЯНЖМАА

 Д.АРИУНАА

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:  Ж.ГЭРЭЛТУЯА